



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас:26-04-37, Факс:51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ТАНАА

2024.04.19 № 07/1024
танай _____-ны № _____-т

Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх”-ийг хянаж, дүгнэлт гаргахаар зохицуулсан болно. Энэхүү заалтын хэрэгжилтийн хүрээнд Төрийн аудитын байгууллага сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт аудит хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Төрийн аудитын байгууллага бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээ нь хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянаж, дүгнэлтийг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817:2020 - Төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэх ба дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалт тусгасан эсэх;
- Бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх;
- Мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар хянах;
- Тодруулах зүйлсийг тухай бүр мэдэгдэх бөгөөд аудитын явцад нэмэлт мэдээлэл, тайлбар авах;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгуулж дахин дүгнэлт гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу бие даан нэр дэвшигч нь дараах үүрэг хариуцлагыг хүлээхээр байна. Үүнд:

Z:\Yawsan_Bichig\2024\0419 SNAG-5.Docx

0001051167

- Бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 04 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагад ирүүлнэ;
- Сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна;
- Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлнэ.
- Сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Та сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл /энэхүү захидлын нэг ба хоёрдугаар хавсралт/ мөн мөрийн хөтөлбөрийн 3 эх хувийг хэвлэмэл байдлаар, хувийг /файл хэлбэрээр/ дугтуйнд хийж битүүмжлэлтэйгээр Үндэсний аудитын газар /Засгийн газрын IV байр 4 давхарт 401 тоот өрөөнд/ ажлын цагаар хүлээлгэн өгнө;
- Сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө биечлэн өгөх боломжгүй тохиолдолд, мөрийн хөтөлбөрийн хуудас бүрт гарын үсэг зурж, иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулах эсхүл хүчин төгөлдөр цахим лавлагааг хавсаргаж Монгол шуудангийн "Чингэлтэй дүүрэг 1 дүгээр хороо Бага тойруу-3 Засгийн газрын IV байр" хаягт шуудангаар ирүүлж болно.

Мөн аудитын зорилгоор хүссэн нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр баталгаажуулж өгөх, аудитад шаардлагатай тохиолдолд ярилцлага тодруулга өгч хамтран ажиллахаас гадна дараах зүйлийг анхаарна уу. Үүнд:

- Бие даан нэр дэвшигч нь Төрийн аудитын байгууллагатай өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан харилцах бол нотариатаар баталгаажсан итгэмжлэлтэй байх, итгэмжлэгдсэн төлөөлөгч солигдсон бол тухай бүр мэдэгдэх бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, харилцах утасны дугаар, цахим шууданг итгэмжлэлд тусгасан байх;
- Бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө биечлэн өгөх бол иргэний үнэмлэх эсхүл хүчин төгөлдөр лавлагаатай ирэх;
- Төрийн аудитын байгууллагаас нийцээгүй дүгнэлт гарсан бол уг дүгнэлтийг биеэр ирж авах боломжгүй тохиолдолд шуудангаар хүргүүлэх тодорхой хаяг, цахим хаяг, утасны дугаараа ирүүлэх.

Жич: Талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага болон бидний гүйцэтгэх аудитын нөхцөлтэй танилцсан гэдгээ илэрхийлж хариу мэдэгдэхийг хүсье.

Хавсралт...*2*...хуудастай.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Үндэсний аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 19-ний
өдрийн 07 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан 2024 оны УИХ-ын
ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт нэмж ирүүлэх мэдээлэл

ATA9593 9006109
9023030583

№	Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг баримталсан эсэх (тийм, үгүй)	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр, холбогдох заалтыг бичих	Тайлбар
	1	2	3	4
1	Жишээ: Цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг 87.7 хувь хангана	Жишээ: Тийм Санхүүжилтийн эх үүсвэр Усан цахилгаан станцын төслийн нийт хөрөнгө оруулалт 818.0 тэрбум төгрөг, олон улсын банк санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 95 хувийг, улсын төсвөөс 5 хувийг санхүүжүүлнэ. Дулааны цахилгаан станцад нийт 808.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд эх үүсвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлэхээр нийт хөрөнгө оруулалтад ТХХ түншлэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтын харьцаа 70:30 байхаар тооцоолов. Төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулж, 3 жилийн хугацаанд санхүүжүүлэхээр төлөвлөсөн	Жишээ: Алсын хараа 2050, ЭЗ-ийн тэргүүлэх чиглэлүүд, Зорилт 4.2- ын 8 дах заалт	Жишээ: МУ-ын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 7,145.7 сая кВт.цаг буюу 80.7 хувийг дотоодын үйлдвэрлэлээс 20... хангасан. Үлдсэн 19.3 хувь буюу 1,705.6 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг 14 дэд станцаар дамжуулан импортоор худалдан авсан. Эрчим хүчний хэрэгцээг 7% өсгөж хангахаар тооцож, 90 МВт-ын усан цахилгаан станц, 450 МВт-ын дулааны цахилгаан станц барьж ашиглалтад оруулахаар МХ-т тусгав.
2				

Жич:

- 2 дугаар баганад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг баримталсан эсэх
- 3 дугаар баганад Монгол Улсын хөгжлийн бодлогын ямар баримт бичгийн аль заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.


Мэдээллийг бэлтгэсэн _____/бие даан нэр дэвшигч/

(Овог нэр)

/гарын үсэг/

Үндэсний аудитын газрын 2024 оны 04 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт нэмж ирүүлэх мэдээлэл



№	Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Хамрах хугацаа	Шаардагдах санхүүгийн эх үүсвэр (Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 20.2.1-20.2.6 дахь заалт)	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн нийт дүн	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ төсвийн жил тус бүрээр (тэрбум төгрөгөөр)				Тайлбар
					202 ...	202 ...	202 ...	202 ...	
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Жишээ: Цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг 87.7 хувь хангана	Жишээ: 2024-2028	Жишээ: 20.2.1.улсын төсөв; 20.2.2.гадаадын зээл; 20.2.5.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ;	Жишээ: 1'626.2 тэрбум төгрөг	406.6	406.6	406.6	406.6	Жишээ: Санхүүжилтийг 4 жилд тэнцүү зарцуулахаар төлөвлөв.
	Бүгд дүн								

Жич:

- 3 дугаар баганад шаардагдах санхүүгийн эх үүсвэр нь ХБТТУТХ -ийн 20.2.6 дахь заалтад хамаарна гэж мэдээлсэн тохиолдолд энэ ангилалд хамааруулах үндэслэл, тайлбар, нотлох зүйлийн хамт ирүүлнэ.

Мэдээллийг бэлтгэсэн _____/бие даан нэр дэвшигч/
(Овог нэр) /гарын үсэг/

2024 оны ... сарын ... өдөр